

Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийн 2019 оны аудитын зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан



№	Аудитын зөвлөмж	Гүйцэтгэсэн ажлууд
1	Одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт хууль тогтоомжтой нийцээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн батлуулсан.
2	Дотоод хяналтын эрсдэлийн төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.	Дотоод хяналтын нэгж ажилтаны ажлыг төлөвлөгөөнд тусган холбогдох дүрэм журмыг шинэчлэн батлуулсан. Энэ төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
3	Сангийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 251 дугаар тушаалаар санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ шинэчлэгдэж 1 цагийн аудитын үйлчилгээний төлбөрийн хэмжээ нэмэгдсэн байна.	Сангийн сайдын тушаалаар баталсан аудитын үйлчилгээний төлбөрийн жишигт нийцүүлэн төсвийн өөрчлөлтийн санал хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд явуулж 2 500 000 төг болгон 2020 оны төсөвт нэмж батлуулсан.
4	Тус байгууллагын менежер Э.Янжинсүрэн, нийгмийн ажилтан Д.Доржналжирмаа нар нийт 5,381.8 мянган төгрөгийн цалин бүхий танхимын 28 цаг илүү ажилласан байна.	Хөдөлмөрийн сайд, сангийн сайдын хамтарсан А/198/215 дугаар тушаалаар баталсан журмыг 2.6 дахь заалт, Хөдөлмөр нийгмийн хамгаллын сайдын баталсан багц цагийн журмыг баримтлан ажиллаж байна.
5	Тус сургуулийн захиралд дээд шатны тушаал шийдвэргүйгээр 1,999.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгосон байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын тушаалаар ур чадварын нэмэгдлийг олгож байна.
6	Шатахууны зарцуулалтыг батлагдсан нормтой харьцуулахад тайлант онд нийт 319.1 мянган төгрөгийн буюу 174 литр шатахуун илүү зарцуулсан байна	Шатахууны зарцуулалтыг батлагдсан нормын дагуу олгож байна.
7	Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай"-г мөрдөж ажиллаагүй байна.	Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай"-г мөрдөж зориулалтын дагуу ашиглаж байна.